



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2026/039/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Дорнод аймаг</p> <p>2026 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Нармандах Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakh@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг. 21000
Утас: 7058-4203

2026-01-26 № 03/33
танай 2026-01-26 ны № 03/33 -т

ДОРНОД АЙМГИЙН СЭРГЭЛЭН
СУМЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Д.ЭНХЖАРГАЛАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67.2-т "Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газраас нэг бүрчлэн буюу нэг маягаар тогтоох бөгөөд нийслэлийн Засаг даргын тамгын газар нь газар, хэлтэс, тасагтай, аймаг, сум, дүүргийн Засаг даргын тамгын газар нь хэлтэс, тасагтай байна", Засгийн газрын 267 тогтоолоор "Хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, үйлчлэх өрх, аж ахуйн нэгж, байгууллагын тоог харгалзан сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг 1500 хүртэл хүн амтай суманд 13, 1501-3000 хүртэл хүн амтай суманд 15, 3001-5000 хүртэл хүн

2126050059

амтай суманд 16, 5001-10000 хүртэл хүн амтай суманд 18, 10001-20000 хүртэл хүн амтай суманд 21, 20001-ээс дээш хүн амтай суманд 23 байхаар тус тус тогтоосугай"- гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн Сэргэлэн сумын ЗДТГ нь 2025 онд 2 зорилт, 162 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний биелэлтийг "Хангалттай" буюу 86.7 хувиар үнэлүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	260,264,906.21	269,398,190.61
35	БАРАА МАТЕРИАЛ	165,961,735.00	167,375,519.40
354	Хангамжийн материал	68,865,735.00	70,279,519.40
35410	Бичиг хэргийн материал	2,871,975.00	2,850,655.40
35420	Аж ахуйн материал	32,667,002.00	34,178,144.00
35430	Сэлбэг хэрэгсэл	5,005,000.00	5,255,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,238,444.00	2,619,060.00
35470	Бусад хангамжийн материал	27,083,314.00	25,376,660.00
35600	Мал амьтад	97,096,000.00	97,096,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	94,303,171.21	102,022,671.21
36300	Тэжээлийн нөөц	94,303,171.21	102,022,671.21
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,116,227,006.11	3,492,291,838.61
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,116,227,006.11	3,492,291,838.61
392	Биет хөрөнгө	2,997,502,006.11	3,373,754,338.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,116,098,893.01	1,840,672,205.41
39202	Хуримтлагдсан элэгдэл	(99,592,757.78)	(151,294,518.98)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	147,380,095.00	144,885,295.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(39,484,996.64)	(42,832,745.84)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	267,985,360.00	257,736,230.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(153,257,288.69)	(162,498,781.49)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	84,035,657.20	65,595,537.54
39208	Хуримтлагдсан элэгдэл	(67,933,425.89)	(36,622,113.33)
39209	Зам, гүүрийн байгууламж	764,587,054.70	846,491,141.70
39210	Хуримтлагдсан элэгдэл	(201,322,195.92)	(274,539,706.08)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,197,551,027.08	1,321,701,027.08
39215	Хуримтлагдсан элэгдэл	(358,671,026.96)	(435,539,232.40)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	340,125,611.00	-
393	Биет бус хөрөнгө	118,725,000.00	118,537,500.00
39301	Програм хангамж	4,156,200.00	4,156,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,031,200.00)	(3,218,700.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	117,600,000.00	117,600,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,376,491,912.32	3,761,690,029.22
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,376,491,912.32	3,761,690,029.22
51	Засгийн газрын хувь оролцоо	3,376,491,912.32	3,761,690,029.22
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	613,345,543.20	613,345,543.20
51101	Өмч: - төрийн	613,345,543.20	613,345,543.20
512	Хуримтлагдсан үр дүн	2,585,106,247.03	2,970,304,363.93
51210	Өмнөх үеийн үр дүн	1,158,276,003.70	2,585,106,247.03
51220	Тайлант үеийн үр дүн	1,426,830,243.33	385,198,116.90
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	178,040,122.09	178,040,122.09
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,376,491,912.32	3,761,690,029.22

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,833,055,166.79	2,022,805,847.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,730,179,210.88	986,571,620.34
120	Нийтлэг татварын бус орлого	1,730,179,210.88	986,571,620.34
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	268,800.00	200,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	268,800.00	200,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,567,210,526.88	959,239,620.34
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	162,699,884.00	27,132,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,102,875,955.91	1,036,234,227.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	48,589,955.91	3,913,727.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	47,309,955.91	3,913,727.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	280,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,054,286,000.00	1,032,320,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,054,286,000.00	1,032,320,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,255,164,189.46	1,292,006,939.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,199,732,975.46	1,239,101,519.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,061,672,058.81	1,212,723,465.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	677,371,779.04	750,624,681.23
210101	Үндсэн цалин	365,119,382.51	396,674,742.22
210102	Нэмэгдэл	278,357,129.53	314,223,103.56
210104	Урамшуулал	33,895,267.00	39,726,835.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,849,184.24	92,203,816.84
210201	Тэтгэврийн даатгал	56,635,641.40	65,855,202.32
210202	Тэтгэмжийн даатгал	6,692,695.59	6,285,178.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,104,447.25	3,744,239.31
210204	Ажилгүйдлийн даатгал	2,416,400.00	3,744,239.31
210205	Эрүүл мэндийн даатгал	-	12,574,957.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,715,047.07	65,596,573.90
210301	Гэрэл, цахилгаан	3,494,437.07	3,309,073.90
210302	Түлш, халаалт	21,220,610.00	62,287,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,280,602.91	28,467,155.60
210401	Бичиг хэрэг	3,747,018.91	2,026,769.60
210402	Тээвэр, шатахуун	18,177,584.00	19,634,344.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,947,400.00	2,262,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,108,300.00	1,012,000.00
210408	Бараа материал акталсны зардал	1,300,300.00	3,532,042.00
2105	Нормативт зардал	-	600,000.00
210502	Хоол, хүнс	-	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,533,500.00	3,924,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,090,000.00	407,000.00
210604	Урсгал засвар	4,443,500.00	3,517,000.00
2107	Томилолт, зочны зардал	15,189,500.00	5,155,000.00
210702	Дотоод албан томилолт	15,189,500.00	5,155,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,156,711.00	1,587,741.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	254,500.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	342,300.00	448,290.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	224,100.00	234,632.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	140,975.00	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	880,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	314,836.00	332,819.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	225,575,734.55	264,564,497.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,730,593.00	21,910,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		5,080,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	177,845,141.55	237,573,997.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	138,060,916.65	26,378,054.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	85,686,337.00	574,927.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	45,934,129.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	34,492,748.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,259,460.00	574,927.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	52,374,579.65	25,803,127.03
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	52,374,579.65	25,803,127.03
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	55,431,214.00	52,905,420.00
2200	Дотоод эх үүсвэрээр	55,431,214.00	52,905,420.00
223001	Бусад хөрөнгө	55,431,214.00	52,905,420.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,577,890,977.33	730,798,907.74
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	151,060,734.00	345,600,790.84
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	10,462,050.00	345,600,790.84
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	140,598,684.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(151,060,734.00)	(345,600,790.84)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,426,830,243.33	385,198,116.90

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,103,144,755.91	1,036,434,227.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	268,800.00	200,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	268,800.00	200,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	268,800.00	200,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	268,800.00	200,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,102,875,955.91	1,036,234,227.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	48,589,955.91	3,913,727.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	47,309,955.91	3,913,727.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	280,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,054,286,000.00	1,032,320,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,054,286,000.00	1,032,320,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,027,895,541.91	979,091,757.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,027,895,541.91	979,091,757.00

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	889,834,625.26	952,713,702.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	677,371,779.04	750,624,681.23
210101	Үндсэн цалин	365,119,382.51	396,674,742.22
210102	Нэмэгдэл	278,357,129.53	314,223,103.56
210104	Урамшуулал	33,895,267.00	39,726,835.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,849,184.24	92,203,816.84
210201	Тэтгэврийн даатгал	56,635,641.40	65,855,202.32
210202	Тэтгэмжийн даатгал	6,692,695.59	6,285,178.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,104,447.25	3,744,239.31
210204	Ажилгүйдлийн даатгал	2,416,400.00	3,744,239.31
210205	Эрүүл мэндийн даатгал	-	12,574,957.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,400,227.07	65,596,573.90
210301	Гэрэл, цахилгаан	3,494,437.07	3,309,073.90
210302	Түлш, халаалт	20,905,790.00	62,287,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,133,470.91	21,139,170.00
210401	Бичиг хэрэг	3,139,918.91	2,005,450.00
210402	Тээвэр, шатахуун	16,235,112.00	15,440,720.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,947,400.00	2,262,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	276,040.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,535,000.00	1,431,000.00
2105	Нормативт зардал	1,400,000.00	600,000.00
210502	Хоол, хүнс	-	600,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,400,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,053,400.00	4,819,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,304,900.00	560,000.00
210604	Урсгал засвар	5,748,500.00	4,259,000.00
2107	Томилолт, зочны зардал	15,189,500.00	5,155,000.00
210702	Дотоод албан томилолт	15,189,500.00	5,155,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,156,711.00	1,587,741.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	254,500.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	342,300.00	448,290.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	224,100.00	234,632.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	140,975.00	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	880,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	314,836.00	332,819.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,280,353.00	10,987,720.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,280,353.00	5,907,720.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	5,080,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	138,060,916.65	26,378,054.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	85,686,337.00	574,927.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	45,934,129.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	34,492,748.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,259,460.00	574,927.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	52,374,579.65	25,803,127.03
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	52,374,579.65	25,803,127.03
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	75,249,214.00	57,342,470.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	75,249,214.00	57,342,470.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	75,249,214.00	57,342,470.00

2200	Дотоод эх үүсвэрээр	75,249,214.00	57,342,470.00
223001	Бусад хөрөнгө	75,249,214.00	57,342,470.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(75,249,214.00)	(57,342,470.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	613,345,543.20	178,040,122.09	1,158,276,003.70	1,949,661,668.99
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	613,345,543.20	178,040,122.09	1,158,276,003.70	1,949,661,668.99
Тайлант үеийн үр дүн	-	-	1,426,830,243.33	1,426,830,243.33
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	613,345,543.20	178,040,122.09	2,585,106,247.03	3,376,491,912.32
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	613,345,543.20	178,040,122.09	2,585,106,247.03	3,376,491,912.32
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	613,345,543.20	178,040,122.09	2,585,106,247.03	3,376,491,912.32
Тайлант үеийн үр дүн	-	-	385,198,116.90	385,198,116.90
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	613,345,543.20	178,040,122.09	2,970,304,363.93	3,761,690,029.22

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	-	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	685,250,000.00	678,398,900.00	6,851,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	685,250,000.00	661,872,965.24	23,377,034.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	685,250,000.00	661,872,965.24	23,377,034.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	765,232,500.00	750,624,681.23	14,607,818.77
210101	Үндсэн цалин	402,296,100.00	396,674,742.22	5,621,357.78
210102	Нэмэгдэл	327,950,900.00	314,223,103.56	13,727,796.44
210104	Урамшуулал	34,985,500.00	39,726,835.45	(4,741,335.45)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,033,900.00	92,203,816.84	(11,169,916.84)
210201	Тэтгэврийн даатгал	54,145,900.00	65,855,202.32	(11,709,302.32)
210202	Тэтгэмжийн даатгал	6,429,000.00	6,285,178.64	143,821.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,806,100.00	3,744,239.31	61,860.69
210204	Ажилгүйдлийн даатгал	3,811,100.00	3,744,239.31	66,860.69
210205	Эрүүл мэндийн даатгал	12,841,800.00	12,574,957.26	266,842.74

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,426,400.00	1,587,741.00	1,838,659.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	1,760,000.00	440,000.00	1,320,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,080,000.00	5,180,000.00	(100,000.00)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	100,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,080,000.00	5,080,000.00	-
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	200,000.00	(200,000.00)	-
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.00	200,000.00	-
	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,913,727.00	3,913,727.00	-
	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,913,727.00	3,913,727.00	-

2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	53,660,400.00	50,471,343.92	3,189,056.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	53,660,400.00	50,471,343.92	3,189,056.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	53,660,400.00	50,471,343.92	3,189,056.08
2103	БАЙР АШИГЛАЛТАЙ ХОЛБООТОЙ ТОГТМОЛ ЗАРДАЛ	50,660,400.00	47,471,343.92	3,189,056.08
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	53,660,400.00	50,471,343.92	3,189,056.08
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	53,660,400.00	50,471,343.92	3,189,056.08

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 16.6 сая төгрөгийн 3 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулах бичилт хийлгэж аудитын явцад залруулсан.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Залруулсан алдаа:

- Үндсэн хөрөнгийн шинжийг агуулсан 8.3 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн нь “УСНББОУС 1 Санхүүгийн тайлагналын толилуулга”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

“Санхүүгийн тайлангийн толилуулга” батламж мэдэгдлийг хангаагүй тул аудитын явцад санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгө дансанд бүртгэж залруулав.

- Бараа материал дансанд бүртгэлтэй 4.9 сая төгрөгийн бараа материалын ангиллыг өөрчилж залруулав. Энэ нь “УСНББОУС 1 Санхүүгийн тайлагналын толилуулга”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, “Санхүүгийн тайлангийн толилуулга” батламж мэдэгдлийг хангаагүй тул залруулав.
- Цалин нийт зардал, нийгмийн даатгал, ХХОАТ-ын тайлангийн тайлагнасан дүнг 3.4 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн “20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шалгуур журмын 4.1.3-т “Хүчин төгөлдөр анхан шатны баримтыг үндэслэн Сангийн сайдын тушаалаар батлагдсан заавар, журам болон УСНББОУС-ын дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтлөх” 4.1.5.Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үндэслэн батлагдсан төсвийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулж, төрийн өмч, төсвийн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэх” гэсэнтэй нийцэхгүй байсныг залруулсан.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 8,157.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 10,433.0 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өгөв.

Аудитаар нийт 6.8 сая төгрөгийн 4 зөрчил² илэрснээс 0.3 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 6.4 сая төгрөгийн 2 албан шаардлага, өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасанд сахилгын шийтгэл ногдуулах 1 албан шаардлага хүргүүлэв.

5.1 Төлбөрийн акт

1. Үндэсний хорооны II хурал цахим /zoom meeting/ хэлбэрээр зохион байгуулагдахаар бичиг ирсэн байхад 3 ажилтанд тус бүр 2 хоногийн томилолтын нөхөх олговор олгохдоо 1 албан хаагчийн 340,000 төгрөгийн томилолтын зардлыг илүү олгосон байна. Томилолтын баримт дээр огноо, нягтлан бодогчийн тооцоолол гарын үсэг дутуу, анхан шатны баримтын бүрдэл дутуу байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасантай зөрчсөн тул төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Төсөвт төлөвлөсөн ахмадын сангаас 3,064.0 мянган төгрөгийн зарцуулалт хийхдээ холбогдох анхан шатны баримтуудыг хавсаргаагүй, нотлох баримт хангалтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасантай нийцээгүй тул албан шаардлага өгөв.
2. Зардлыг анхан шатны баримттай тулгахад шатахууны зардлыг дээд шатны байгууллагаас баталсан жишиг нормтой тулган хяналт хийгээгүй, зардлыг 3,393.6

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Зам, тээвэр хөгжлийн яамны 2019 оны 390 дүгээр "Жишиг норм батлах тухай" тушаалын 1 дүгээр хавсралт "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-д заасантай нийцээгүй тул албан шаардлага өгөв.

3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчлийг тайлант онд давтан гаргасныг албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. УИХ-ын 48 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт: ЗГ-ын 2009 оны 13 дугаар тогтоолоор сумын засаг даргын тамгын газрын орон тооны хязгаарыг тогтоосноос тус сумын ЗДТГ-ын хүн амын тооноос үндэслэн орон тооны хязгаарыг 2025 оны байдлаар 2802 хүн амтай /1501-3000/, жишиг нормын дагуу 15 хүний орон тоотой байхаар байна. Засаг даргын 2025.01.10-ны өдрийн А/01 захирамжаар нийт 18 орон тоотой байхаар баталсан нь УИХ-ын 48 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдыг чадавхжуулах, чиг үүргийн давхардлыг арилгахад чиглэгдсэнд арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Тогтоолын хэрэгжилтийг хангаж чиг үүргийн давхардлыг арилгаж ажиллах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад 30 хоногийн дотор, харин зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/					
							Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй			
Үндсэн хөрөнгийн шинжийг агуулсан хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн	1	8,350.7					1	8,350.7				
Бараа материалын ангилал зөрүүтэй бүртгэлийг зассан	1	4,890.2					1	4,890.2				
Цалин, НД, ХХОАТ-ын тайлангийн зөрүү	1	3,358.9					1	3,358.9				
Дүн	3	16,599.8					3	16,599.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Томилолтын зардлыг хэтрүүлэн олгосон	1	340.0	1	340.0	-	-	-	-	-	-	-	-
Шатахууныг баталсан жишиг норм, нормативаас хэтрүүлэн зарцуулсан	1	3,393.6	-	-	1	3,393.6	-	-	-	-	-	-
Ахмадын сангаас анхан шатны баримтгүй ажил гүйлгээ хийсэн, баримтын иж бүрдэл дутуу	1	3,064.0	-	-	1	3,064.0	-	-	-	-	-	-
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг зөрчсөн зөрчлийг давтан гаргасан	1								1	0		
Дүн	4	6,797.6	1	340.0	2	6,457.6	-	-	1	0.0	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант хугацаанд оруулбал зохих 183 мэдээллээс хугацаа хоцорч мэдээлсэн 9, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 658.1 сая төгрөгийн 26 гүйлгээний мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчил гаргасан байна	1	658,137.4	-	-	1	658,137.4	-	-
Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, зөрчлийг давтан гаргасан	1	-			1	Хариуцлага тооцох		
УИХ-ын 48 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой зөрчил								
15 хүний орон тоотой байхаар хязгаарыг хэтрүүлж 18 орон тоогоор ажиллаж байна	1	-	-	-	-	-	1	-
Нийт дүн	3	658,137.4	-	-	2	658,137.4	1	-